

Хүний эрх хөгжил төвийн 2015-2018 оны стратегийн хэрэгжилт

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүний эрх хөгжил төв “Хүн бүрийн оролцох, хөгжих эрхийг хангасан хөгжингүй Монгол Улс” байгуулах алсын хараа, “Хүмүүний эрхээр хөгжил рүү!” уриатай 2015-2018 оны стратегийг хэрэгжүүлэн 20 жилийн ойг угтаж байна. Энэ стратеги нь ядуурлыг бууруулах, байгаль орчны тэнцвэрийг хамгаалах, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх нөхцөл зөвхөн хүний эрхийг хангах замаар бүрдэнэ гэсэн бидний итгэл, үнэмшил дээр суурилсан. Стратегийн зорилтийг орон нутгийн иргэдийн шийдвэр гаргахад оролцох, хэрэгжилтийг хянах, үнэлэх, хариуцлага тооцох **хамтын чадавхийг** хөгжүүлэх; тэдний хүний эрх, хөгжил, байгаль орчны асуудлаар орон нутгийн захиргаатай хамтарч ажиллах зохион байгуулалттай үйл ажиллагааг дэмжих гэж тодорхойлон **Хүний эрхийн хамгааллын хөтөлбөр**, **Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөр**, **Хамт олонд суурилсан хөгжлийн хөтөлбөр** гэсэн гурван хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүллээ.

Хүний эрхийн хамгааллын хөтөлбөр:

- Хүний эрхийн үндэсний бүтэц механизмыг бэхжүүлэхэд дэмжих зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус үйл ажиллагаа, санхүүжилтийг Парисын зарчимд нийцүүлэх зорилготой үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэх жил бүр хийдэг ажлыг үргэлжлүүлэх. 2018 онд бид 12 дахь удаагийн үнэлгээний тайланг хүргүүлээд байна.
- Олон улсын хүний эрхийн механизмыг үр дүнтэй хэрэглэх зорилгоор НҮБ-ын Хүний эрхийн хороо, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн хороо, Хүний эрхийн зөвлөлийн Тогтмол түгээмэл хэлэлцүүлэгт зориулж хүний эрхийг хамгаалах үндэсний бүтэц механизм, эрх зүйн орчин, ядуурал, хүнсний эрх, байгаль орчны хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа асуудал зэрэг сэдвээр дангаар болон бусад байгууллагуудтай хамтран илтгэл бичиж, хэрэгжилтийг хянаж байна. Энэ оны 12 сараас эхлэн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 3-р мөчлөгийн Түгээмэл тогтмол хэлэлцүүлэгт зориулан хүний эрхийн тодорхой хэдэн сэдвээр дүгнэлт, зөвлөмж гаргуулах илтгэл бэлтгэх ажилд орно.
- Хүний эрх хамгаалагчдын Үндэсний зөвлөгөөнийг 2015 оноос эхлэн жил бүр зохион байгууллаа. 2018 онд 4-р зөвлөгөөн боллоо. Нийт 4 удаагийн зөвлөгөөнд Улаанбаатар хот болон орон нутгаас 200 орчим хүний эрх хамгаалагчдыг оролцуулан үйл ажиллагааны нэгдсэн стратегитай болох, харилцаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг ажлыг хийж байна.
- Ахмад настны хүний эрхийн хэрэгжилтээр үнэлгээ хийх, үндэсний болон орон нутгийн хэмжээнд олон талт хэлэлцүүлэг зохион байгуулах, ахмад настны хүний эрхийг хамгаалах олон улсын конвенцийн агуулга боловсруулах олон улсын судалгаанд оролцох, конвенцийг боловсруулах НҮБ-ын Нээлттэй ажлын хэсгийн хуралдаанд 2 удаа төлөөлөгчдөө илгээн үг хэлүүлэх, үндэсний бодлого боловсруулахад ахмад настны эрхийн хэрэгжилтийг сайжруулахад чиглүүлэх зорилготой оролцох зэргээр ажиллаж байна.

Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөр:

- Хүний эрхийн олон улсын өдрийг иргэд мэддэг болох, тэмдэглэдэг болох, асуудлаа ярьдаг болох уламжлалыг тогтоох зорилготой Хүний эрхийн олон улсын өдрийг тэмдэглэх санаачлага гарган хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум, орон нутагт байгаа ХЭХТ-ийн харъяа Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбоодтой хамтарч ажиллаж байна. Нээлттэй цуглааныг 2015 оноос эхлэн “Хүний эрх хамгаалагчдыг хамгаалъя”, “Оролцооны эрхээ баталгаажуулъя”, “Иргэний нийгмийн оролцоотой Тогтвортой хөгжлийг бүтээе” “Хүний эрхийн ТББ-дын нээлттэй өдөрлөг” зэрэг сэдвээр зохион байгуулав. Жилээс жилд оролцогчдын

тоо нэмэгдэж байна. 2016 оноос эхлэн Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймгийн төв, Сүхбаатар аймгийн Онгон, Дарьганга сумдад зохион байгуулж байна. 2016 онд нийт 1000 орчим хүмүүс оролцсон байдаг.

- Монгол улсыг хүний эрхэд суурилсан хөгжлийн бодлоготой болгох, хүний эрхийн тулгамдсан асуудлуудад төрийн бодлогыг чиглүүлэх, хүний эрхэд суурилсан бодлого боловсруулах улс төрийн намуудын чадавхи бий болгох зорилгоор 2016 оноос эхлэн жил бүр улс төрийн намуудтай уулзалт зохион байгуулж хүний эрхийн тулгамдсан асуудлаар мэдээлэл өгч байна. Энэ уулзалтуудад хүний эрхийн форумын гишүүд, орон нутгийн хүний эрх хамгаалагчид оролцдог. 2018 оны 11 сард улс төрийн намуудтай хийх 3 дахь уулзалтаа зохион байгуулсан. Энэ уулзалтаар үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө, бизнес ба хүний эрхийн асуудал, хүний эрх хамгаалагчийн тухай хуулийн төсөл, түүнийг батлуулах зэрэг асуудлаар мэдээлэл өгсөн.
- Орон нутгийн иргэдийг тулгамдсан асуудлаа хуулийн хүрээнд тайван замаар өргөн хүрээний оролцоотойгоор шийдүүлдэг болох чадавхи бий болгох, жишиг тогтооход анхаарч ажиллаж байна. Үүний жишээ нь Дорнод аймгийн 11 сумын нутаг дэвсгэрт байдаг экологийн үнэ цэнэтэй 13 нэр бүхий газрыг газрыг улсын тусгай хамгаалалтанд авахуулах аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр гаргуулах нөлөөллийн ажлыг эдгээр сумдын 3000 гаруй иргэдийн оролцоотой зохион байгуулж, 6 сумын 9 нэр бүхий газрыг улсын тусгай хамгаалалтад авах шийдвэр гаргуулсан.
- Газар нутгийг тусгай хамгаалалтанд авах, байгалийн нөөцийн менежментийг зохион байгуулахад иргэдийн оролцоог хангах чадавхи бэхжүүлэх хүний эрх, эрх зүйн сургалтуудыг нийт 6 аймгийн 67 суманд зохион байгуулж 2700 малчдыг хамруулсан.
- Дорнод аймгийн Дашбалбар сум, Дорноговь аймгийн Улаанбадрах суманд байгаль орчны шударга ёс болон уурхайн компани, орон нутгийн захиргааны хооронд байгуулсан хамтын гэрээний хэрэгжилтийг хянах орон нутгийн иргэдийн мэдлэг мэдээллийг сайжруулах, чадавхи бэхжүүлэх сургалт, судалгааг орон нутгийн иргэдийн оролцоотой хийсэн.
- Гадаадын зээл тусламж болон иргэний нийгмийн байгууллагын хөгжлийн үр нөлөөг сайжруулах Хөгжлийн хамтын ажиллагааны дэлхийн түншлэлийн хүрээнд хийдэг хоёр дох удаагийн мониторингд оролцон иргэний нийгмийн оролцооны орчин, түүнийг төрийн болон олон улсын хөгжлийн байгууллагууд хэрхэн институтчилсан байдлыг үнэлэх, хэлэлцүүлэг хийх зэрэг ажил хийж байна.

Хамт олонд суурилсан хөгжлийн хөтөлбөр:

- Тус хөтөлбөр нь ХЭХТ-ийн үйл ажиллагааг хөрсөнд буулгаж үр шимийг хүмүүст хүртээдэг хөтөлбөр. Хөтөлбөрийн зорилго нь орлого багатай иргэдийг нэгтгэн тэдний эдийн засаг нийгэм соёлын эрхийг иргэний улс төрийн эрхээр нь хамгаалах, хэрэгжүүлэх, нэхэмжлэх хамтын хүч бий болгох, орон нутгийн хөгжилд оролцох, хөгжлийн үр шимийг хүртэх чадавхи бий болгох, хамтын ажиллагааг үүсгэх, бэхжүүлэх зорилготой.
- Хөтөлбөр хүрээгээ улам тэлж байна. Нийт 5 аймгийн төв, 6 сум, нийслэлийн 1 дүүргийн 2 хороонд үйл ажиллагаа явуулж байна. Хөтөлбөрт 880 гишүүд 64 бүлэг, 8 холбоонд нэгдэн ажиллаж байна. Хамтын үйл ажиллагаа, хүчийг бэхжүүлэхэд анхаарч түрүүчээсээ 13-14 дэх жилдээ хамтаараа ажиллаж байна.
- Энэ хөтөлбөрийн үр дүнд давхардсан тоогоор 8560 гаруй өрх, 15458 иргэдийн орон байр, амьдрах орчин сайжирсан. 60 гаруй өрх орон байраа сайжруулах буцалтгүй тусламж авсан.
- Мөнгөн хуримтлалын бүлгийн гишүүд, ахлагчид, Хамт олны хөгжлийн сангийн зохицуулагчид, МХБХ-дын дарга нарт орон нутагт нь болон Улаанбаатарт олон тооны сургалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулжээ. Бүлгийн гишүүдийн төсөл хэрэгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлыг тогтмол хийж байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 38 гишүүдийг олон улсад болдог сургалт, семинар, туршлага солилцох уулзалтуудад оролцуулсан.

- Оролцооны эрхийг хэсэгжүүлэхтэй холбоотой шинээр гарч байгаа хууль, эрх зүйн акт, бодлого, хөтөлбөртэй тогтмол танилцуулах, хэрэглэх чадавхи бий болгох зорилготой сургалтуудыг хийж байна.
- Жил болгон Туршлага солилцох чуулган зохион байгуулдаг. 2018 онд 12 дох удаагийн чуулган болсон. Чуулганд жил бүр 200-аад гишүүд оролцдог. Чуулганы зардлыг 100% өөрсдөө санхүүжүүлдэг. Зарим холбоод 10 гаруй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж орон нутгийн захиргааны дэмжлэг авах, хамтарч ажиллах талаар баялаг туршлага хуримтлуулж байна.
- Бүлгийн гишүүд ихэд чадавхижиж орон нутгийн сонгуульд оролцож эхэлсэн. 2016 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд манай бүлгүүдийн гишүүдээс багийн ИНХ-ын дарга 3, ИНХ-ын хурлын тэргүүлэгч, сумын ИТХ-ын гишүүнээр 7 хүн сонгогдсон. Баг, сумын ахмадын зөвлөлийн даргын сонгуульт ажлыг 4 хүн хашиж байна.
- Хуримтлалтай болж санхүүгийн үйлчилгээг өөрсдөдөө хүргэж байна.
- ТХЗ 2030, ТХҮБ 2030-ыг орон нутагт хүргэх, орон нутгийн иргэдийн мэдээллийг сайжруулах, хэрэгжилтэд оролцох, хамтарч ажиллах чадавхийг бий болгох сургалтыг МХБХ-дын гишүүдэд зохион байгуулж, Дорнод аймгийн Чойбалсан, Баяндум сум, Хэнтийн аймгийн Хэрлэн сумдад ТХЗ-1, ТХЗ-8 –ын зорилтуудыг үнэлэх, тулгамдсан асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг МХБХ-дын дарга нарын удирдлага доор байгуулан ажиллаж байна.
- МХБХ-д орон нутагт хүний эрхийн өдрийг зохион байгуулах, нутаг усаа хамгаалалтад авах, хүний эрх, ахмадын эрхийн хэрэгжилтээр судалгаа авах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг компанит ажлуудыг хийж байна.

Цаашдын стратеги боловсруулахад:

1. Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх
2. Хүний эрхийн олон улсын механизмыг үр дүнтэй ашиглаж хүний эрхийн тулгамдсан асуудлыг гаргаж тавих, төрийн бодлого, хөтөлбөрт оруулах
3. Хүний эрх хамгаалагчийг хамгаалах, үндэсний сүлжээг бэхжүүлэх
4. Ахмад настны хүний эрхийг хамгаалах
5. Олон нийтийн хүний эрхийн мэдлэг, мэдээллийг сайжруулах
6. Хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах, эрх зүйн орчинг бий болгох
7. ТХЗ-дыг хүний эрхийн тулгамдсан асуудлуудтай холбох, хөгжлийн бодлогыг хүний эрхийн зарчмаар боловсруулж, хэрэгжүүлэх чадавхи бэхжүүлэх
8. Хүний эрхийн боловсролыг институтчилах.
9. Энэ бүх үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулах, тэднээр хэрэгжүүлэх, олон талын эрх тэгш, үр дүнтэй түншлэлийг хөгжүүлэх,
10. МХБ, Холбоодыг тэлэх, шинэ сум, аймгуудыг хамруулах, зохион байгуулалтыг бэхжүүлэх, үйл ажиллагааны үр нөлөөг улам сайжруулах

2019 оны хугацаанд 2015-2018 оны стратегийн хэрэгжилтийг үнэлэх, 2019-2022 оны стратеги боловсруулах ажлыг хийнэ.